

БАТЛАВ.  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА

Т.ЖАМБААЖАМЦ



МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ЗАЙНЫ  
БОЛОН ГАЗАР ДЭЭРХ ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ЭРСДЭЛИЙН ҮНЭЛГЭЭНИЙ  
ПРОГРАММЫН ЗАГВАР БОЛОВСРУУЛАХ ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭ

2024 оны 09 дүгээр сарын 02

Улаанбаатар хот

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Монгол Улс нь Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (ФАТФ)-ын Ази, Номхон далайн мөнгө угаахтай тэмцэх бүлэг (АНДМУТБ)-ийн гишүүн орны хувьд Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх (МУТСТ) үйл ажиллагааг идэхтэй хэрэгжүүлж, Харилцан үнэлгээний бэлтгэл ажлыг хангаж ажиллах шаардлагатай. Энэ ажлын хүрээнд манай улс ФАТФ-ын стандарт, зөвлөмжийг мөрдөж ажиллах үүрэгтэй бөгөөд ФАТФ-ын Техникийн зөвлөмж 1, Зөвлөмж 26, Зөвлөмж 28 болон Шууд хэрэгжилт 1, Шууд хэрэгжилт 3-д тус тус заасны дагуу зохицуулалттай мэдээлэх үүрэгтэй этгээдүүдийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх (МУТС) эрсдэлийг үнэлж, эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагатай.

Уг ажлын хүрээнд Үндэсний мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог бэхжүүлэх, АНДМУТБ-аас хийх дараагийн Харилцан үнэлгээнд бэлтгэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 265 дугаар тогтоолоор батлагдсан “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөр”-ийн Зорилго 4-т “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэх эрсдэлд суурилсан бодлого, арга хэмжээг авч хэрэгжүүлэх” ажил тусгагдсан. Энэ хүрээнд үндэсний МУТС эрсдэлийг тогтмол хянах, салбарын болон мэдээлэх үүрэгтэй этгээдийн эрсдэлийг оновчтой тодорхойлж, эрсдэлд суурилсан аргачлалыг хэрэгжүүлэх, мэдээлэх үүрэгтэй этгээд өөрийн үйл ажиллагааны түвшинд эрсдэлийн үнэлгээг тогтмол хийх, шинэчлэх зэрэг зорилтуудыг тусгасан.

Санхүүгийн зохицуулах хороо нь банкнаас бусад салбарын мэдээлэх үүрэгтэй этгээдэд хяналт, шалгалт хийх, зохицуулалтаар хангах эрх бүхий этгээдийн хувьд тус Хорооны 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 22 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам”-д заасны дагуу өөрийн зохицуулалттай салбаруудын мэдээлэх үүрэгтэй этгээдээс мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх эрсдэлийн үнэлгээний асуулгыг хагас жил тутам эксел файл хэлбэрээр авч, Олон Улсын Валютын Сангийн аргачлал, хэрэгслийг ашиглан механик аргаар эрсдэлийн үнэлгээг хийж гүйцэтгэж байна.

Гэвч сүүлийн жилүүдэд тус Хорооны зохицуулалтын хамрах хүрээ өргөжиж, зохицуулалтын байгууллагуудын бүтээгдэхүүн үйлчилгээний төрөл нэмэгдэж байгаатай холбоотойгоор эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг боловсронгуй болгох, эрсдэлийг үнэлэх аргачлал, тоон болон чанарын өгөгдөл цуглуулах маягт, шалгуур үзүүлэлтийг зах зээлийн өсөлт, олон улсын стандартад нийцүүлэн шинэчлэх, мэдээлэх үүрэгтэй этгээд болон хянан шалгагчдад ногдох гар ажиллагааг багасгаж хяналт шалгалтыг бодит цагийн горимоор тасралтгүй хэрэгжүүлэх, дээрх процессыг автоматжуулах шаардлага үүсэж байна.

## ХОЁР. АЖЛЫН ЗОРИЛГО

Энэхүү ажлын даалгавар нь ФАТФ-ын Зөвлөмж 1, Зөвлөмж 26, Зөвлөмж 28 болон Шууд хэрэгжилт 1, Шууд хэрэгжилт 3-ын үзүүлэлтийг үр дүнтэй хэрэгжүүлэх, 2027-2028 онуудад хийгдэх ээлжит Харилцан үнэлгээнд бэлтгэхийн сацуу хязгаарлагдмал нөөцийг үр ашигтайгаар хуваарилах, албан хаагчдын ажлын ачааллыг тогтворжуулахад технологийн шийдлийг хяналт шалгалтад нэвтрүүлж, бодит цагийн горимоор хянах боломжийг бүрдүүлэх, эрсдэлийг урьдчилан тодорхойлж, үүнээс сэргийлэх арга хэмжээ авах, төр болон хувийн хэвшлийн байгууллагуудтай стратегийн түвшинд хамтран ажиллах буюу Зээлийн мэдээллийн сан, ХУР, ДАН, И-Монголиа зэрэг бие даасан системүүдтэй холбогдох цогц эрсдэлийн үнэлгээний программын загварыг боловсруулах зорилготой болно.

## ГУРАВ. АЖЛЫН ХҮРЭХ ҮР ДҮН

МУТСТ зайны болон газар дээрх хяналт шалгалт, эрсдэлийн үнэлгээний программын загварыг боловсруулах зөвлөх үйлчилгээ авснаар дараах боломжууд бий болно. Үүнд:

- МУТС эрсдэлийн үнэлгээний программын бүтэц, харагдах байдал, мэдээллийн орц, гарц, боловсруулалтыг системжүүлж, загвар боловсруулснаар МУТС эрсдэлийн үнэлгээний хангамжийг хөгжүүлэх суурь болно;

- МУТС эрсдэлийн үнэлгээг боловсронгуй болгож, олон улсын стандартад нийцүүлснээр, МУТС эрсдэлийг илүү өргөн цар хүрээнд үнэлж, түүнд тохирох хянан шалгалтын хэрэгслийг ашиглах боломжтой болно;
- Мэдээлэх үүрэгтэй этгээд болон хянан шалгагчдад ногдох гар ажиллагааг багасаж, цаг хугацаа хэмнэх, механик алдаа гарах эрсдэлийг бууруулах нөхцөл бүрдэнэ;
- ФАТФ-ын Зөвлөмж 1, Зөвлөмж 26, Зөвлөмж 28 болон Шууд хэрэгжилт 1, Шууд хэрэгжилт 3-ын үзүүлэлтийг үр дүнтэй хэрэгжүүлнэ;
- ФАТФ-ын ээлжит Харилцан үнэлгээнд бэлтгэж, эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг боловсронгуй болгоно.

### ДӨРӨВ. АЖЛЫН ХАМРАХ ХҮРЭЭ

Тус ажлын даалгаврыг эрсдэлийн үнэлгээний программын зураглал (UI/UX) гаргах болон программ хангамж боловсруулах компани ашиглана. Шаардлагатай тохиолдолд ХШЗГ-ын МУТА-ны албан хаагчид болон Мэдээллийн технологийн хэлтэс санал өгнө.

### ТАВ. ТАВИГДАХ ШААРДЛАГА

Гүйцэтгэгч МУТСТ чиглэлээр эрсдэлийн үнэлгээний программ боловсруулахад ашиглагдах загварыг боловсруулах ба зохицуулалтын салбар бүрийн онцлогт тохирсон эрсдэлийн хүчин зүйлсийг хамруулж, ажлын даалгаврыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- Бүтцийн эрсдэл: үйл ажиллагаа явуулсан хугацаа, эзэмшлийн төрөл, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчийн тоо г.м.;
- Бизнесийн эрсдэл: үйл ажиллагаа явуулж буй газар, байршил, салбарын тоо, байршил, эрхэлж буй үйл ажиллагааны төрөл хэлбэр, цар хүрээ, нийт харилцагчдын тоо, харилцагч дунд УТНБЭ, гадаад улсын болон оршин суугч бус этгээд, ашгийн бус байгууллага байдаг эсэх, бэлэн мөнгөний гүйлгээ гардаг бол түүний хэмжээ, давтамж, ФАТФ-ын жагсаалтад орсон улс орнууд болон өндөр эрсдэлтэй гэж үзсэн улс орнуудаас гүйлгээ хүлээн авдаг/дамжуулдаг буюу аливаа холбоотой эсэх, нүүр нүүрээ харахгүйгээр зайнаас, гуравдагч этгээдээр дамжуулан үйлчилгээ үзүүлдэг эсэх, нэрээ нууцалсан харилцагчдад үйлчилгээ үзүүлдэг эсэх, бүтээгдэхүүн үйлчилгээг агент буюу өөр бусад сувгаар дамжуулан хүргэдэг эсэх г.м.;
- Комплаенсын эрсдэл: Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг хэрхэн яаж биелүүлж байгаатай холбоотой мэдээлэл г.м.

### ЗУРГАА. АЖЛЫН ХУГАЦАА

МУТС эрсдэлийн үнэлгээний программын загварыг боловсруулах ажлын даалгаврыг 1 сарын дотор боловсруулж тус Хорооны Хяналт шалгалт, зохицуулалтын газрын Мөнгө угаахтай тэмцэх алба болон Мэдээллийн технологийн хэлтэст хүргүүлнэ. Шаардлагатай

тохиолдолд программын зураглал (UI/UX) гаргах болон программ боловсруулах компаниудад танилцуулна.

#### ДОЛОО. ГҮЙЦЭТГЭГЧИД ТАВИГДАХ ШАЛГУУР

- МУТСТ чиглэлээр холбогдох мэдлэгтэй эсхүл ажлын туршлагатай;
- Мэдээлэл, технологийн чиглэлээр мэргэшсэн, энэ салбарт ажиллаж байсан туршлагатай хуулийн этгээд байх;
- Эрсдэлийн үнэлгээний программ боловсруулж байсан туршлагатай;
- Эрсдэлийн үнэлгээний программын загварыг цаашид программын зураглал (UI/UX) гаргах болон эрсдэлийн үнэлгээний программ боловсруулах компаниуд хэрэгжүүлэхэд ойлгомжтой хэлбэрээр боловсруулсан байх;
- Чанарын өндөр түвшинд, стандартын шаардлагад нийцүүлэн гүйцэтгэх;
- Захиалагч талаас хүргүүлсэн ажлын даалгаврыг бүрэн гүйцэт, цаг хугацаанд нь гүйцэтгэх;
- Эрсдэлийн үнэлгээний программ боловсруулахад тус ажлын даалгавар суурь болох тул шаардлагатай тохиолдолд тайлбар хийж, харилцан мэдээлэл солилцох боломжтой байх.